

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд олон нийтэд мэдээ мэдээллийг түгээх, тэдэнд зориулсан соёл танин мэдэхүй, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлуудыг дараах байдлаар зохион байгуулан ажиллав.

3. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

3.2.1. Нийслэлийн суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх, суурь судалгааг оновчтой хийж, олон нийтэд хөрсний бохирдлын талаар ойлголт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна

“Агаарын бохирдол”, “Гэр хорооллын дахин төлөвлөлт”, “Ногоон Улаанбаатар”, картын санд 6 нэр төрлийн тогтмол хэвлэлийг ашиглан шинээр буюу үргэлжлүүлэн хийж 119 нийтлэл мэдээгээр баяжуулав.

“Утаанаас хамгаалах арга”, “Агаарын бохирдолоос сэргийлье”, “Агаарын бохирдол ба эрүүл мэнд”, “Улаанбаатар хотын түүхээс”, “Бүгдээрээ мод тарья”, “Мод бол хүчилтөрөгч үйлдвэрлэгч” гэх мэт сэдвүүдээр 15 төрлийн цуврал үзэсгэлэнг 104 ширхэг материалаар зохион байгууллаа. Уг үзэсгэлэнг давхардсан тоогоор 1322 хүн хамрагдлаа.

“Бидний гэр-Эко орчин” сэдэвчилсэн номын үзэсгэлэн, “Агаарын бохирдол гэж юу вэ?”, “Агаарын бохирдлын хор нөлөө”, “Байгаль хамгаалах уламжлалт ёс”, “Эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ?” зөвлөмж, мэдээллийг 32 ширхэг материалаар 4 удаа гаргасныг 150 орчим иргэн сонирхсон.

Агаарын бохирдлын хор уршгийг танин мэдүүлэх, утааны чанарын асуудлыг танин мэдэх, ялгаж сурах, ард иргэдийн агаарын бохирдолтой хэрхэн тэмцэх талаар сургалтыг АНУ-ын ЭСЯамны Байгаль хамгаалал, Эрүүл мэндийн хэлтэс, “Монголын 4 Навч” ТББ, “Гэр хорооллын зураглал” ТББ, “Маск” төслийн баг зэрэг газруудтай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийтдээ 136 хүн хамрагдсан байна.

4. НИЙГМИЙН ХӨГЖИЛ: 4.1. Боловсрол

4.1.17. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Эрдмийн аялал” аян зохион байгуулж, Шинжлэх ухааны Академийн харьяа хүрээлэн, номын сан, музей, түүхийн дурсгалт газар, орон нутгийн байгууллага, үндэсний үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах аялалыг тогтмол зохион байгуулна.

“Эрдмийн аялал” аяны хүрээнд 148, 247-р цэцэрлэг, ерөнхий боловсролын 5, 23, 24, 33, 47, 48, 86, 107 Эрдмийн ундраа цогцолбор сургууль, Атланта дунд сургууль, Англи хэлний “Кингс Кидс” бүрэн дунд сургууль, “Шинэ иргэншил” МСҮТ, “Бичил ертөнц” дунд сургууль, “Нарлаг” хүүхдийн зуслан, Их Засаг Их сургууль, БНСУ-ын Намьянжү хотын номын сангийн

нийт **943** орчим сурагч хүүхдүүд, иргэдийг төв болон салбар үйл ажиллагааг танилцуулж, уншигчаар бүртгэн, уншсан номынхоо талаар саналаа солилцож тэмдэглэл хөтлөх арга ажиллагааны талаар тойм яриа зохион явууллаа.



4.3. Соёл, урлаг

4.3.1. Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аяныг өрнүүлнэ.

Номын санч, ажилтнуудад зориулан “Харилцаа хандлага” сэдэвт уулзалтыг “Хүний хөгжил” оюуны төвийн гүйцэтгэх захирал Б.Мөнгөний урьж зохион байгуулсан.

Мөн "Ном унших соёл" сэдэвт уулзалт, зөвлөмжийг Боловсролын хүрээлэнгийн тэргүүлэх багш, хэл шинжлэлийн ухааны доктор соёл судлаач Д.Баттогтох, "Харилцааны соёл" сэдэвт чөлөөт уулзалт ярилцлагыг СТА Ч.Уранхолбоотой хамтран тус тус зохион байгууллаа. Уулзалта нийт 100 орчим сурагч хүүхдүүдийг хамруулсан.

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ
Улаанбаатар хотын нийтийн төв номын сан

ЦАГИЙН ХУВААРЬ:
Өвлийн цагийн хуваарь:
/09 сарын 16-06 сарын 15/
Даваа-Баасан 09:00-20:00
Бямба, Ням 10:00-19:00

ТА БАР КОДОО НААНА УУ.

Зуны цагийн хуваарь
/06 сарын 16-09 сарын 15/
Даваа-Баасан 09:00-18:00
Бямба, Нямд Амарна

ГОРЬКИЙН НЭРЭМЖИТ 1-Р САЛБАР НОМЫН САН
Салбар номын сангийн уншлагын танхим

- Уншлагын танхимээр ном авахдаа уншигч нь иргэний үнэмлэхээ үзүүлж үйлчлүүлнэ.
- Уншигч уншлагын танхимд нэг удаад 1-4 ширхэг номыг 6 цаг хүртэл хугацаагаар авч болох ба авсан номын тооцоог бүрэн дусгаж, дараагийн захиалгыг өгөх.
- 1-3 хуваарь, эрэлт хэрэгцээ ихтэй номыг 2 цаг хүртэл хугацаагаар ашиглуулах.
- Гэрээ авсан номын хугацаа хэтэрсэн тохиолдолд насанд хурагч хоног тутамд ном тус бүрээр 2000Т, хүүхэд 1000Т торгуулийг тус тус төлөх.
- Уншиж ашиглах авсан ном хэвэл бусад материалыг гэмтэх, хуудсыг ураг, эрсэж авах, тэмдэглэл хийх, доогуур нь зураж, хуудсыг нугалах зэргийг хориглоно.
- Уншлагын танхимд бусдын тайвныг алдагдуулах, гар утсаар ярих, гар утасны дуг хаяхгүй байх, чанга ярих, инээх, хашгирах, бохь зөвлөх зэргийг хориглоно.
- Уншигч та ном болон номын сангийн эд зүйлсэд хайр гэмтэй хандан бусдыг болоод өөрийгөө хүндлэн соёлтой үйлчлүүлээрэй.

Холбоо барих утас: 77179909
Page хаяг: Горькийн нэрэмжит 1-р салбар номын сан



Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан нь “Хотын соёл номын сангийн соёл мөн” аяныг үргэлжлүүлэн үйлчлүүлэгчдэд зориулсан шаардлагатай мэдээлэл агуулсан уншигчийн үнэмлэх хэвлүүлэн 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс олгож эхлэв. Номын санд бүртгүүлэн хэвлэж авсан бар кодоо наах, үйлчилгээний цагийн хуваарь, холбоо барих утас, хаяг байршил зэрэг шаардлагатай мэдээллийг багтааж өгсөн карт юм. Одоогийн байдлаар 200 орчим уншигчдад уг үнэмлэх тараагдсан.

4.3.2. Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн цахим хэлбэрт шилжүүлж, алслагдсан дүүргийн соёлын ордны номын сангийн хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийлээ.

1. Алслагдсан дүүргүүдийн соёлын ордуудын номын сангуудыг Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн Коһа сүлжээнд бүрэн хамруулахтай холбогдуулан дээрх номын санчдад КОХА програмд ном каталогжуулах нэгдсэн болон ажлын байрны ганцаарчилсан, мөн онлайн сургалтыг нийтдээ 5 удаа зохион байгууллаа.

Коха програмд ном каталогжуулж оруулах ажлын явц 2018 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар:

- Багануур дүүргийн соёлын ордны номын сан 7782 ш – 60,4%
- Багахангай дүүргийн соёлын ордны номын сан 1596 ш – 78%
- Жаргалант дүүргийн соёлын ордны номын сан 29 ш – 1,1%
- Налайх дүүргийн соёлын ордны номын сан 198 ш – 1,6% номуудыг тус тус оруулаад байна.

2. Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйлчилгээг RFID /цахим номын сан/ технологийг үйлчилгээндээ нэвтрүүлэх ажлыг үргэлжүүлэх ажлын хүрээнд төв номын сангийн үйлчилгээнд RFID технологийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэхэд шаардлагатай үлдэгдэл тоног төхөөрөмжийн судалгаа гарган 2018 оны 04 дүгээр сард Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт тендерийн материалыг хүргүүлэн 2018 оны 08 дугаар сард тендер зарлагдан “БАЯНМОГОД” ХХК шалгарсан.

Тус компаниас RFID технологийн тоног төхөөрөмжүүдийг 2018 оны 12 дугаар сарын эхээр хүлээн авч, инженер О.Цог туршилтыг хийж байгаа. Туршилт хийгдэж байх явцад Ном бүрдүүлэх, тусгай үйлчилгээний тасаг tag буюу ялтасыг номонд нааж суулгах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Ийнхүү эхний ээлжинд RFID технологийг төв номын сангийн “А” танхимд бүрэн нэвтрүүлэх боломжтой болж байна.

4.5. ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ:

4.5.7. Нийслэлд “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ.

Ч.Лувсанжав, Ш.Бадарч, Ш.Энхбаяр нарын уран бүтээлийн жишээ нь дээр “Хүүхдийн зохиолын намтар бичлэг, аялгуут болон бичгийн үлгэр зохиолын өнөөгийн байдал” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд 56 уншигч хамрагдсан.



“Миний хайртай ээж” зохион бичлэгийн уралдаанд нийт 23 хүүхэд оролцож 1-р байранд 5-р сургуулийн 6б ангийн сурагч Мягмардорж, 2-р байр тус ангийн Б.Намуундарь нар шалгарлаа.

“Америкт суралцах 5 алхам” сэдэвт лекцийг АСМТ-ийн ажилтан Одмаа ирж америкт хэрхэн тэтгэлэгээр суралцах боломж байгаа тухай мэдээлэл өгсөн. Уг лекцэнд 50-р сургуулийн 12б ангийн төлөөлөл нийт 25 уншигч идэвхтэй оролцсон.

“Эрүүл мэндийн зөвлөгөө”, “Энхрий үрийнхээ төлөө та юуг мэдвэл зохих вэ?”, “Хүмүүжлийн эерэг арга ба ардын ухаан”, “Ээждээ зориулсан шүлгэн хэлхээ”, “Аз жаргалтай гэр бүл” сэдэвт 99 ширхэг материалаар, “Гэр бүлийн эрүүл мэнд” сэдэвчилсэн номын үзэсгэлэн 2 удаа 35ш номоор тус тус гаргав.

БЗД-ийн 45-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн А.Нарантуяа багштай бяцхан уншигчдын хүүхдийн баярын арга хэмжээнд нь оролцож “Дотно найз” номоор чанга уншлага хийлээ.

“Эссэ хэрхэн бичих вэ?” сэдвээр зохиолч П.Батхуягтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтад 10-12-р ангийн 18 сурагч хамрагдлаа.

Ерөнхий боловсролын 1, 47, 136-р дунд сургуулийн 107 сурагчдад, сургуулийн өмнөх насны 32-р цэцэрлэгийн 45 хүүхдүүдэд “Улаан малгайт” үлгэрээр, “Ховдог хулгана” үлгэрээр, “Нэмнээтэй хонь” үлгэрээр тус тус чанга уншлага хийсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “ШУВУУ” аппликейшний танилцуулга, зөвлөмж яриаг 1 удаа 40 хүн хийлээ.

Хоёр. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр улс орон даяар уламжлагдан зохион байгуулагддаг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-үүдээр дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа

Уулзалт:

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Ууганбаатарын “Бичиг үсгийн түүх, гарал” сэдэвт лекцэнд СУИС-ийн оюутнууд, “Шинэ иргэншил” МСҮТ-ийн сурагчид, Хүүхдийн урлан бүтээх төвийн нийт 32 уншигч хамрагдав.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ё.Мөнхбаттай “Монголчуудын бичиг үсгийн соёл” сэдэвт уулзалтыг зохион байгуулсан. Нийт 30 уншигч оролцсон.

МУБИС-ийн Нийгмийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн Монгол хэлний багш доктор дэд профессор Л.Жумдаан Үндэсний бичиг үсгийн түүх соёл гарал үүслийн талаар ЕБ-ийн 18, 52, 75-р дунд сургуулийн ахлах ангийн 43 сурагчидтай харилцан ярилцан, уран бичлэгийн хичээлийг заалаа.

Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Ц.Түмэнбаяртай уран бүтээлийн уулзалт зохион явууллаа. Уулзалтанд 28 уншигч хэрэглэгч оролцлоо. Зохиолчийн уран бүтээл болох 9 номоор номын үзэсгэлэн гаргасан.



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ё.Мөнхбаттай хийсэн уулзалт



ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ж.Ууганбаатартай хийсэн уулзалт



Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт зохиолч Ц.Түмэнбаяртай уран бүтээлийн уулзалт



Үзэсгэлэн:

- “Уйгаржин монгол бичгээр бичигдсэн номууд” – 12 ширхэг ном, 28 ширхэг хэвлэмэл материалаар,
- “Монголчуудын бичиг, үсгийн түүх, соёл” – 14 ширхэг номоор,
- “Уйгаржин монгол бичиг бидний өв” – 26 ширхэг мэдээлэл, 13 ширхэг боть номоор,
- “Соёлын баримтат өв” – 13 ширхэг судраар,
- “Эх хэл соёл” – 15 ширхэг номоор,
- “Ховор номын үзэсгэлэн” – 22 ширхэг номоор,
- “Үндэсний бичиг үсгийн өдөр” – 15 ном, 10 судар, 5 хэвлэмэл хуудсаар,
- “Эх хэлээрээ зөв тод ярьж сурцгаая” 8 хуудас мэдээлэл
- “Монголчуудын бичиг үсгийн түүх” 8 хуудас мэдээлэл
- “Үндэсний бичиг үсгийг баяр” – 18 ном, 14 хэвлэмэл хуудсаар тус тус үзэсгэлэн гаргалаа.

Нийт 10 үзэсгэлэн гаргаж, уг үзэсгэлэнд 109 номоор, 63 хэвлэмэл хуудас, 23 судраар тус тус үзэсгэлэн зохион байгууллаа.



Мэдээлэл, зөвлөмж:

- “Уйгаржин монгол бичгийн онцлог” – 8 хуудас мэдээлэл, зураг
- “Монголчуудын түүхэн бичиг үсэг, гарал” – 16 хуудас мэдээлэл
- “Эх хэлээрээ зөв тод ярьж сурцгаая” - 8 хуудас мэдээлэл
- “Монголчуудын бичиг үсгийн түүх” - 8 хуудас мэдээлэл

Уралдаан:

Эх хэлээрээ зөв бичиж сурах, монгол хэлний хичээлээр олсон мэдлэгээ бататгах, эх хэл соёлоо хайрлан хамгаалах сэтгэл зүйг төлөвшүүлэх зорилгоор “Алтан үсгийн цоморлиг” уралдаанд 10 сурагч, “Үсэглэлийн хаад” зөв бичгийн уралдаанд ЕБ-ын 93-р дунд сургуулийн 44 сурагч, “Монгол бичгээр хэн сайн бичих вэ?” уралдаанд 105 сурагч, “Ном миний мөрөөдөл” эссэ бичлэгийн уралдаанд нийт 11 сурагч, асуулт хариултын “Алтан хонх” уралдаанд 20 хүн тус тус хамрагдлаа.



Эрдмийн аялал:

Ерөнхий боловсролын 47-р дунд сургуулийн Ононмөрөн багштай 76 анги, 48-р дунд сургуулийн Оюунтуяа багштай 9а ангийн 102 сурагчдыг номын сантай танилцуулах аялалыг зохион байгууллаа.

Номоо солилцъё:

Үндэсний бичиг үсгийн баярт зориулсан “НОМОО СОЛИЛЦЪЁ” өдөрлөг 2018 оны 05 сарын 04, 05-ны өдрүүдэд болж өнгөрлөө. Өдөрлөгийн үйл ажиллагаанд 50 гаруй хувь хүмүүс, иргэд, мөн С.Буяннэмэхийн нэрэмжит “Номын өргөө”-нийхөн оролцож, номоо солилцов. Тус өдөрлөгөөр Хотын төв номын сан 50 гаруй номоор, “Номын өргөө”-нийхөн 69 номоор тус тус солилцоо хийж, фондоо баяжууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагааг MNC, VTV телевизээр тус тус сурталчиллаа.



2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг

Эх орон байгаль дэлхийгээ хайрладаг, Монгол зан заншлаа дээдэлж хүн бүр байгалиа нөхөн сэргээх хамгаалахад гар бие оролцох нөхцлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 5, 10 сарыг бүх нийтээр “МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР” болсонтой холбогдуулан Монгол улсын байгаль орчны гавьяат ажилтан, биологийн ухааны доктор, Яруу найрагч Бадрахын Чимэдтэй “Мод тарих арга, арчилгааны” талаар уулзалт ярилцлага зохион байгууллаа.



3. Нийслэлийн Засаг даргын 2012 он “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 дугаар захирамж

Тайлангийн хугацаанд иргэдэд мэдээллийг ил тод, шуурхай хүргэх ажлын хүрээнд твиттерт 1348 жиргээ илгээгдэж, 456 дагагчтай, байгууллагын фейсбүүк хуудас 34855, үүнээс гадна АСМТ 16213 дэмжигчтэйгээр нийгмийн сүлжээгээр мэдээллийг түгээж байна.

4. Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Мэдээллийн аюулгүй байдлын журам” А/477 дугаар захирамж

Мэдээллийн системийг холбогдох стандартын дагуу зохион байгуулж ажилладаг бөгөөд номын сангийн үйл ажиллагаа, цаг үеийн шинжтэй мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нийтэд ub.pl.gov.mn, UB Public Library.Facebook цахим хуудсанд тухай бүрт байршуулж байна.

Байгууллага дотооддоо захирлын тушаал, үүрэг даалгавар, ажилтан, албан хаагчдын хувийн хэрэг, өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллүүдийг ажилчдын дотоод Facebook page болон дотоод сүлжээгээр мэдээллэдэг.


Номын сангийн нийт байр талбайн 10 хүртэлх хувь буюу үндсэн фонд болон Серверийн өрөө хаалттай бүсэд тооцогддог. Үндсэн номын фонд, серверийн өрөөнд зөвхөн эрх бүхий албан тушаалтан нэвтрэх эрхтэй бөгөөд аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажилладаг.

Ашиглагдаж байгаа бүх компьютер техник хэрэгслийг мэдээллийн ажилтнууд бүртгэлжүүлж, засвар үйлчилгээ, шинэ програм хангамж нэмэгдэх бүрт програмист болон хариуцагч ажилтан нар гарын үсэг зурж баталгаажуулдаг.

Мэдээллийн системийг хууль бус халдлагаас хамгаалах галт хана ашиглаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, илрүүлэх зориулалтаар хамгаалалт, хяналтын техникийн систем, зориулалтын програм хангамжинд байнга хяналт тавьж ажиллаж байна.

5. Нийслэлийн Засаг даргын 2014 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх тухай батлах тухай” А/718 дугаар захирамж

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс 2018 оны 10 дугаар сарын 18-нийг хүртэлх хугацаанд 105448 хэрэглэгч зочилж /visits/, 265658 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 84,1% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 15,9% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Users	% Users
1. Mongolia	93,696	93.80%
2. United States	1,352	1.35%
3. South Korea	1,004	1.01%
4. Russia	643	0.64%
5. Japan	483	0.48%
6. France	417	0.42%
7. Germany	204	0.20%
8. United Kingdom	164	0.16%
9. China	137	0.14%
10. Australia	133	0.13%

6. Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам батлах тухай” А/633 дугаар захирамж

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журмын дагуу ажлаас чөлөөлөгдсөн 12, жирэмсний амралтаа авсан 2, шинээр болон эгүүлэн томилогдсон 7, шилжин ажилласан 8, хавсран ажиллаж байгаа 4 ажилтнуудын ажил хүлээлцэх комиссын гишүүдийг томилж, уг журмын хавсралт ажил хүлээлцэх маягтын дагуу цахим болон цаасан баримт, эд хөрөнгийг хүлээлцүүлэн тус бүр 3 хувь үйлдсэн.

7. Нийслэлийн Засаг даргын 2017 оны “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам батлах тухай” А/252 дугаар захирамж

1.5 дахь заалтын дагуу энэхүү журмыг үндэслэл болгон “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг шинэчлэн боловсруулж номын сангийн захирлын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/14 дугаар тушаалаар баталсан. Уг журмыг холбогдох ажилтнуудад танилцуулсан.

2.6 дахь заалтын дагуу захирлын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/17 дугаар тушаалаар номын сангийн зохион байгуулалтын 6 нэгжид индекс олгож баталлаа.

2.9 дэх заалтын дагуу системд хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөгдсөн нийт 7 хэрэглэгчийн эрхийг шилжүүлэх, өөрчлөлт оруулах, цуцлах үйлдлийг програмист холбогдох шийдвэрийг нь үндэслэн тухай бүр хийж гүйцэтгэж байгаа.

Тайлант хугацаанд Edoc системд нийт ирсэн 146 албан бичиг бүртгэгдсэнээс цахимаар 132, НҮНТ-д 2, цаасан суурьтай 12 албан бичиг ирснийг бүртгэсэн ба цаасан суурьтай ирсэн бичигнээс 1 албан бичгийг системд бүртгэх боломжгүй байсан тул бүртгээгүй үлдсэн болно. 140 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан, 3 албан бичгийг судалж байгаа, 3 албан бичгийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд Edoc системээр нийт явуулсан 119 албан бичгийг бүртгэсэн ба үүнээс албан хэрэг хөтлөлтийн систем ашигладаг 63, систем ашиглагдаггүй 56 байгууллага руу албан бичиг бүртгэн хугацаанд нь шилжүүлж шийдвэрлүүлсэн. Хяналтын зөрчилтэй 2, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 албан тоот илэрснийг холбогдох ажилтнуудад мэдэгдэж дахин зөрчил гаргалгүй ажиллах тал дээр зааварчилгаа, зөвлөгөө өгсөн.

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг сард 2 удаа гаргаж, удирдлагад танилцуулж ажилласан. 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар хариутай бичгийн мэдээг хүснэгтээр гаргавал:

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг нийт 18 удаа гаргаж, захиралд танилцуулж, ажилласан.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Дүрмээр хүлээсэн үндсэн үүрэг

3.1.1. Уншлага үйлчилгээ

Төв болон салбар номын сангийн хэмжээнд 2018 оны байдлаар бүтээгдэхүүн нийлүүлэлтийг “хүснэгт 1”-ээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Бүртгэлтэй уншигч	19300	14349	74,3%
2	Ирц	119700	106076	88,6%
3	Ном олголт	299250	235299	78,6%

2018 оны уншлага үйлчилгээний төлөвлөгөөт үзүүлэлтүүд 71-88%-ийн биелэлттэй байгаа бөгөөд тайлант хугацааны төлөвлөгөөт үзүүлэлтийг өнгөрсөн оныхтой харьцуулбал:

Хүснэгт 2


Он		2017			2018		
№	Үйлчилгээ нэр	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Уншигч, хэрэглэгч	19300	15917	82,4%	19300	14349	74,3%
2	Ирц	119700	138675	115%	119700	106076	88,6%
3	Ном олголт	299250	285144	95,3%	299250	235299	78,6%

2018 онд уншигчийн төлөвлөгөө 74,3%-ийн биелэлттэй байгаа бөгөөд өнгөрсөн 2017 онтой харьцуулахад 1568-аар буюу 8,1%-иар буурсан байна.

Тайлант хугацаанд төв болон салбар номын сангийн хэмжээнд ажил хүлээлцэх ээлжит бус 5 удаагийн тооллого хийгдсэн ба Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудад 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн их засварын ажил хийгдэж эхэлсэн. Эдгээрээс шалтгаалан уншлага үйлчилгээний төлөвлөгөөний үзүүлэлт буурсан.

3.1.2. Ном олгох үйлчилгээ

Тайлант хугацаанд уншигч хэрэглэгчдэд **235299** ном хэвлэл олгож үйлчилснээс 17,4% буюу 40920 ширхэг номыг гэрээр олгож үйлчилсэн байна.



3.1.3. Зөөврийн үйлчилгээ

Номын сангийн тухай хууль болон БСШУ-ы Сайдын 2010 оны 570 дугаар “Зөөврийн номын сан ажиллуулах аргачлал” тушаалын дагуу “Ном хөтөлбөр”-ийн хүрээнд:

- Зэвсэгт хүчний 151 дүгээр ангид 50ш ном,
- Зэвсэгт хүчний 120 дугаар ангид 2 удаа 69ш ном,
- 311 дүгээр ангид 10ш ном,
- “Оюутай хүүхэд хөгжлийн төв”-д 92ш ном,
- FIT club Mongolia клубт 53ш ном,
- ШШГЕГ-ын харъяа 407, 429-р хаалттай хорих ангид 331ш ном,
- Чингис хаан нисэх буудлын ажилтнуудад 5 удаа 50ш ном,
- МИАТ-ийн ажилтнуудад 5 удаа 230ш ном,
- Гэрэлт гудамжинд 40ш ном,
- 167-р цэцэрлэгийн багш, ажилчдад 11ш ном,
- ЕБ-ын 6-р дунд сургуулийн 3в ангийн 39 сурагчдад 79ш ном,
- ЕБ-ын 52-р дунд сургуулийн номын сан 37ш ном,
- ЕБ-ын 59-р дунд сургуулийн номын санд 246ш ном,
- ЕБ-ын 75-р дунд сургуулийн номын санд 50ш ном,
- ЕБ-ын 136-р дунд сургуулийн номын санд 2 удаа, 130ш ном,
- Нарлаг зусланд 30ш ном, нийт **1508ш** номоор тус тус зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газартай хамтран сарын бүрийн эхний долоо хоногийн Бямба гаригт зохион байгуулж байгаа “Номоо солилцъё” аяны өдөрлөгт 6 удаа оролцож, нийтдээ 101 ширхэг 656.500 төгрөгийн номоор номын солилцоог иргэдтэй хийж фондоо баяжууллаа.



3.1.4. Интернет үйлчилгээ

3.1.4.1. Вэб хуудас

Нийслэлийн мэдээллийн технологийн газрын серверт байрласан Хотын төв номын сангийн вэб <http://www.pl.ub.gov.mn> -ийн агуулгыг шинэчлэн сайжруулахад анхаарч ажилласан. Google Analytics програмын тусламжтайгаар вэбийн хэрэглээний үзүүлэлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс 2018 оны 12 дугаар сарын 08-нийг хүртэлх хугацаанд тайлан гаргахад 49355 хэрэглэгч зочилж /visits/, 99476 хуудасны мэдээллийг үзсэн.

Манай сайтаар зочилсон


0099476

Visit Today : 73
Visit Yesterday : 140
This Month : 927
This Year : 49355
Total Visit : 99476
Who's Online : 4

Нийт сайтийн хэрэглэгчдийн 71.3% нь шинээр орж, 28.7% нь хуучин хэрэглэгчид хэрэглэгчид зочилсон байна.


Вэб хуудас шинэчлэх ажлын хүрээнд

Байгууллагын вэб сайтын мэдээ, мэдээлэл оруулж тогтворжуулан ажиллаж байна. Мөн вэб сайтад 86 мэдээ, мэдээлэл оруулсан байна.



3.1.4.2. Онлайн каталог, хэрэгчдийн хэрэглээний үзүүлэлт

<http://koha.pl.ub.gov.mn> -ийг Google Analytics тусламжтайгаар каталогт мэдээлэл хайж байгаа үзүүлэлт 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс 2018 оны 10 дугаар сарын 18-нийг хүртэлх хугацаанд 105448 хэрэглэгч зочилж /visits/, 265658 хуудасны мэдээллийг үзжээ. Нийт электрон каталогийн хэрэглэгчдийн 84,1% нь шинээр орж байгаа хэрэглэгчид үлдсэн 15,9% нь хуучин хэрэглэгчид тайлангийн хугацаанд холбогдсон байна.



Тайлангийн хугацаанд сайтад зочилсан хэрэглэгчдийг эхний 10 улс орноор харуулав.

Country	Users	% Users
1. Mongolia	93,696	93.80%
2. United States	1,352	1.35%
3. South Korea	1,004	1.01%
4. Russia	643	0.64%
5. Japan	483	0.48%
6. France	417	0.42%
7. Germany	204	0.20%
8. United Kingdom	164	0.16%
9. China	137	0.14%
10. Australia	133	0.13%

[view full report](#)

3.1.4.3. Интернет сүлжээ

Төв болон салбар номын сангуудад уншигч нарт зориулсан WiFi утасгүй интернэтийн үйлчилгээг үнэ төлбөргүй, мөн харааны бэрхшээлтэй иргэд болон олон нийтэд зориулсан 33 ш компьютерийг өдөрт 1 цаг үнэ төлбөргүйгээр ашиглах боломжийг олгосон.

Тайлангийн хугацаанд Америкийн соёл мэдээллийн төвийн Интернетийн гэрээг сунган 1 жилээр байгуулж гэрээний төлбөрийг шилжүүлсэн.


Америк соёл мэдээллийн төвийн сүлжээний шинэчлэлтэй холбогдуулан шинээр сүлжээний бүх кабелийг сольж шинэ сүлжээ зохион байгуулж нэвтрүүлсэн.

RFID технологийг нэвтрүүлэхтэй холбогдуулан шинээр MIKROTIK CCR-1016 роутер тохируулан тавьсан.

Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангийн интернэтийг Жи-Мобайль ХХК-ийн шилэн кабелиар сольж холболт хийсэн.


Үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 97,38 Mbps, дунджаар 3,37 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 66,96 Mbps, дунджаар 395,65 Kbps хүрсэн байна.




Утасгүй интернэтийн сүлжээ

Утасгүй интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 45.40 Mbps, дунджаар 10.2 Mbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 25.79 Mbps, дунджаар 128.37 Kbps хүрсэн байна.




Америкийн Соёл Мэдээллийн Төв, Хөтөлбөрийн өрөөний утасгүй интернэтийн сүлжээ

Утасгүй интернэтийн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж /download/ байгаа хурд хамгийн ихдээ 79.28 Mbps, дунджаар 1.02 Mbps, түгээж /upload/ байгаа хурд хамгийн ихдээ 54.28 Mbps, дунджаар 134.74 Kbps хүрсэн байна.



Хан-Уул дүүрэг дэх салбар номын сангийн үндсэн сүлжээ

Үндсэн сүлжээний хэрэглээ тайлангийн хугацаанд интернэтийн татаж/download/ байгаа хурд хамгийн ихдээ 72.21 Mbps, дунджаар 685.85 Kbps, түгээж/upload/ байгаа хурд хамгийн ихдээ 17.45 Mbps, дунджаар 70.60 Kbps хүрсэн байна.



Тайлангийн хугацаанд суурин интернэтийг 17443 хэрэглэгч, утасгүй интернэтийг 7261 хэрэглэгч ашиглаж, нийт 24684 хэрэглэгчид интернэтийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Төв болон салбар номын сангуудын интернэт үйлчилгээ хэвийн жигд явагдаж байна.

MAC	Vendor	User	IP	Usage	Time	Action
9c:b7:0d:91:d3:2a	LiteonTe	User	0 B	114 B	11/15/2016 4:42 pm	BLOCK
Sumya	Apple	User	61 MB	7.5 MB	11/15/2016 4:36 pm	BLOCK
Iphone4sss-2	Apple	User	46.6 MB	3.34 MB	11/15/2016 4:25 pm	BLOCK
EgshetThisPhone	Apple	User	501 MB	66.6 MB	11/15/2016 4:24 pm	BLOCK
android-c2ffc4d72218378	Pantech	User	60.3 MB	4.96 MB	11/15/2016 4:23 pm	BLOCK
android-f476cc5542de3f9e	SamsungE	User	685 KB	126 KB	11/15/2016 4:12 pm	BLOCK
android-b3b951db7028758c	SamsungE	User	246 KB	79.1 KB	11/15/2016 4:08 pm	BLOCK
android-4aab786ecdc97980	SamsungE	User	81.9 MB	8.08 MB	11/15/2016 4:02 pm	BLOCK
9c:02:98:47:d0:1f	SamsungE	User	58 MB	4.01 MB	11/15/2016 4:01 pm	BLOCK
tororoos-iPhone	Apple	User	73.1 MB	6.62 MB	11/15/2016 3:46 pm	BLOCK
Bujin	Apple	User	67.6 MB	6.7 MB	11/15/2016 3:43 pm	BLOCK
android-c5014e64b1c80a28	LgElectr	User	42.8 MB	6.94 MB	11/15/2016 3:42 pm	BLOCK
android-c8a939cffffa0cfc	SamsungE	User	2.06 GB	176 MB	11/15/2016 3:34 pm	BLOCK
android-4872610030d198	SamsungE	User	14.3 MB	4.28 MB	11/15/2016 3:34 pm	BLOCK
HUAWEI_P9	HuaweiTe	User	0 B	0 B	11/15/2016 3:19 pm	BLOCK
14sesames-iPad	Apple	User	9.39 MB	1.8 MB	11/15/2016 3:16 pm	BLOCK
Honor_SA	HuaweiTe	User	0 B	0 B	11/15/2016 3:16 pm	BLOCK
android-cc3704d5e788d50e	SamsungE	User	3.21 MB	765 KB	11/15/2016 3:08 pm	BLOCK
Melons-iPhone	Apple	User	26.4 MB	4.16 MB	11/15/2016 3:07 pm	BLOCK
android-22d5a7b29a4b14ef	SamsungE	User	137 MB	11.1 MB	11/15/2016 3:05 pm	BLOCK
DESKTOP-IRQGSJQ	IntelCor	User	5.68 MB	1.03 MB	11/15/2016 2:48 pm	BLOCK
WINCTRL-KAPSN1A	HonHaiPr	User	163 MB	11.6 MB	11/15/2016 2:39 pm	BLOCK
android-c8dafcd0241e490	SamsungE	User	97.3 MB	6.15 MB	11/15/2016 2:30 pm	BLOCK
Tadnba	IntelCor	User	1.15 GB	85.3 MB	11/15/2016 2:29 pm	BLOCK
94:25:db:15:1b:72	SamsungE	User	44.8 MB	2.11 MB	11/15/2016 2:20 pm	BLOCK
android-36220f45ba3c8a2e	Murata-N	User	376 KB	8.25 KB	11/15/2016 2:17 pm	BLOCK
android-4c0a9736ada7fd	SamsungE	User	7.01 MB	1.07 MB	11/15/2016 2:15 pm	BLOCK
BoldkhursiPhone	Apple	User	16.7 MB	1.7 MB	11/15/2016 2:15 pm	BLOCK
Khuan	Apple	User	76.1 KB	83.6 KB	11/15/2016 2:09 pm	BLOCK
android-f9a41328f00ec	SamsungE	User	92.5 MB	8.2 MB	11/15/2016 2:02 pm	BLOCK
iPhone	Apple	User	44.2 MB	4.81 MB	11/15/2016 1:59 pm	BLOCK
DESKTOP-0BA9KNN	LiteonTe	User	4.89 MB	1.52 MB	11/15/2016 1:49 pm	BLOCK
users-iPad	Apple	User	55.7 KB	60.9 KB	11/15/2016 1:38 pm	BLOCK
SaruulKrensiPad	Apple	User	71.6 MB	318 MB	11/15/2016 1:35 pm	BLOCK
android_fffd32d9d1454f3	KiFFTechn	User	0 B	0 B	11/15/2016 12:16 pm	BLOCK
iPhone	Apple	User	5.97 MB	906 KB	11/15/2016 12:07 pm	BLOCK
android-5e1f642df80c20b9	SonyMobi	User	113 KB	95.4 KB	11/15/2016 11:55 am	BLOCK
Smile	Azurewav	User	0 B	141 B	11/15/2016 11:53 am	BLOCK
Zs-iphone	Apple	User	538 KB	191 KB	11/15/2016 11:14 am	BLOCK
UtziljargalsMBP	Apple	User	314 MB	56.8 MB	11/15/2016 11:08 am	BLOCK
Batts-iPad	Apple	User	332 B	456 B	11/15/2016 11:02 am	BLOCK
android-20f000cfe69d58d5	SamsungE	User	0 B	373 B	11/15/2016 11:01 am	BLOCK
android-8a5609a5ffdc700	SamsungE	User	16.4 MB	38.2 MB	11/14/2016 6:33 pm	BLOCK

3.1.4.4. Байгууллагын үндсэн дотоод сүлжээ, тоног төхөөрөмж

Номын сангийн сүлжээг шинээр зохион байгуулж нэвтрүүлсэн ба серверт их цэвэрлэгээ хийсэн. Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг дэх салбар номын сангуудын техник тоног төхөөрөмжийн судалгаа хийж НСУГ-руу хүргүүлсэн.

Төв болон салбар номын сангуудад эвдрэлтэй байсан:

- Компьютерийн үйлдлийн систем- 85
- Тэжээлийн блок- 2
- “Асег” асаах товч- 3
- Вирусны програм- 120
- Сэнс- 3
- Хард -4
- Дэлгэцний карт-1 тус бүрийг засуулж хүлээлгэн өгсөн.

3.1.4.5. Програм хангамж

Номын сангийн үйлчилгээний koHa програм хангамж

Тайлангийн хугацаанд КОХА програмыг туршилтаар суулган нэмэлт өөрчлөлтүүдийг болон каталогийн Tools-д газрын зургийн талбарыг туршиж атласыг координатаар оруулж байна. Одоогийн байдлаар бүх салбар номын сангууд танхимаар болон гэрээр ном олголтын модулийг ашиглаж байгаа.

Номын сангийн камерын систем

Төв номын сангийн хэмжээнд нийт IP технологийн 44ш камерын болон 16 камер, 32 камерийн 2 ш NVR төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Одоогийн байдлаар камерын бичлэг хадгалах төхөөрөмжүүд 4 хүртэлх хоногийн бичлэг хадгалагдаж байна.

Үндсэн фондод 1ш камер суурьлуулсан.

Камерийн хадгалах хугацааг ихэсгэх зорилгоор судалгаа хийж захиралд танилцуулсан.

Мөн үндсэн номын фонд болон судрын фондыг бүрэн камержуулах судалгаа хийж танилцуулсан.

БЗД дэх салбар болон СХД дэх салбар номын сангуудын камерыг шинэчлэх судалгаа хийсэн.

3.1.4.6. Олон нийтийн сүлжээ: Номын сангийн үйл ажиллагааг олон нийтийн сүлжээгээр сурталчлах, уншигчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор төв болон салбар номын сангууд фэйсбүүк хаягийг нээн үйл ажиллагаагаа сурталчилж байна.

Төв номын сангийн <https://www.facebook.com/UBPublicLibrary1> хаяг -34855 дагагч

ЧД дэх салбар номын сангийн Facebook хуудас-186 дагагчтай

ХУД дэх салбар номын сангийн Facebook хуудас-414 дагагчтай

БЗД дэх салбар номын сангийн Баянзүрх номын сан хуудас-5025 найзтай

СХД дэх салбар номын сангийн Цамбагарав номын сан хуудас- 2883 найзтай

Америк Соёл, мэдээллийн төвийн Facebook хуудас-16213 дагагчтай тус тус мэдээлэл түгээж байна.

Twitter


Жиргээ нийгмийн сүлжээгээр нийт 1348 жиргээ илгээгдэж, 456 дагагчтай болсон.



3.1.5. Фондын бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтын талаар

2018 онд 40 нэрийн 274ш 5,524,800 төгрөгийн номыг худалдаагаар, 315 нэрийн 1173ш 9,455,050 төгрөгийн бэлэг хандивын ном, 77 нэрийн 101 ширхэг 656,500 төгрөгийн номыг

солилцоогоор, 4 нэрийн 4ш 37,000 төгрөгийн номыг төлбөрийн номыг, 757 нэрийн 1737ш 34,000,040 төгрөгийн номыг тендерээр тус тус бүрдүүлэн авч АСМТ-ийн 219 нэрийн 239 ширхэг гадаад ном, нийтдээ 3528 ш номонд техник ажиллагаа хийж, 1193 нэрийн 3528ш номын мэдээллийг электрон каталогт оруулан, 3528ш баркод хэвлэсэн байна. Бүрдүүлэлтээр авсан бүх номыг Олон нийтэд үйлчлэх тасаг, салбар номын сангуудад хүлээлгэн өгч уншлаганд шилжүүлээ.




Тогтмол хэвлэлийн захиалгыг чанартай хийж, дугаар ирэлт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж 2018 онд төвлөрсөн номын сангийн хэмжээнд 29 нэр төрлийн 3,361,200 төгрөгийн тогтмол хэвлэл захиалан уншигчдад үйлчилж байна.

КОХА програмд төв номын сангийн үндсэн фондны нийт 250 нэрийн номын мэдээллийг засварласан.

Лавлагаа, номзүйн үйлчилгээ

Мэдээлэл, ном зүйн үйлчилгээний хүрээнд тайлангийн хугацаанд уншигч үйлчлүүлэгч, иргэдэд номын сангийн лавлагааны мессенжер, бичгээр, утсаар, амаар нийт **16047** удаа лавлагаа өгсөн байна.



3.1.6. Ном хэвлэл сэлбэн засах

Урагдаж гэмтсэн нийт **1837ш** номыг хэвлэлтийн анхны жинхэнэ хэлбэр байдлыг алдагдуулахгүйгээр сэлбэн зассан байна. Үүнд:

- Сэлбэн засагч 372 ш ном
- ЧД дэх салбар номын сан 189 ш ном
- ХУД дэх салбар номын сан 137ш ном нэмэгдсэн эсэх
- БЗД дэх салбар номын сан 31 ш ном
- СХД дэх салбар номын сан 138ш ном
- Төв номын сан 970ш ном тус тус сэлбэн зассан байна.

3.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /ХБИ/-ийн мэдээллийн үйлчилгээ

Ярьдаг номын сангийн уншлага, үйлчилгээ

2018 онд 1090 ирцэд 1161 ном олгож үйлчилсний 391 номыг танхимаар, 1190 номыг гэрээр, 30 номыг солилцоогоор тус тус олгож үйлчилсэн байна.

Харааны бэрхшээлтэй иргэдэд 120 удаа лавлагаа өгсөн. Үүнд: Амаар 71, утсаар 43, мессенжерээр 6 удаа тус тус өгсөн байна.

Англи хэлний ярианы клубыг 12 удаа хичээллүүлж давхардсан тоогоор 42 уншигч хэрэглэгч, мөн англи хэлний ганцаарчилсан хичээлийг сайн дурын багшаар 18 удаа заалгаж, 36 уншигч хамруулсан байна. Аньсхан, Хушгахан ТББ-тай хамтарч англи хэлний хичээлийг 9 удаа явуулж нийт 46 оюутан залуус буюу нийтдээ 39 удаа 124 хэрэглэгч хамрагдсан.



“Номын далайд хамтдаа аялъя” уулзалтыг 4 удаа явууллаа. Номын сангийн идэвхтэн уншигч Ц.Отгонбаатар “Сэнтий түшсэн хатад” номоор, 116-р сургуулийн түүх нийгмийн багш Д.Сарантөгс “Зураачийн залуугийн хөрөг” номоор, 116-р сургуулийн 4А ангийн сурагч Сод-Эрдэм Р.М Баллантай “Шүрэн арал” номоор, идэвхтэн уншигч Ц.Отгонбаатар Монгол Улс тунхагласны 94 жилийн ойд зориулж “Монголын нууц товчоо” номоор тус тус тойм яриа бэлтгэж уулзалтыг зохион байгууллаа.



МХҮХ-ын Ярьдаг номын студид 2017 онд хэвлэгдсэн 27 төрлийн номыг файлаар хүлээн авч фондоо баяжуулж, уншигчдын хүртээл болголоо.

Дэлхийн номын өдөрт зориулж сургуулийн бага ангийн хүүхдийн брайль болон товгор үсэгтэй 103 ширхэг номоор номын үзэсгэлэн гаргалаа.



МУИС-ийн ХЗС-ийн 4-р дамжааны оюутан н.Бүжинлхам, н.Баярмаа нар сайн дурын ажил хийж 18-н төрлийн номыг скайнердаж хүртээмжит хэлбэрийн ном болголоо.



Харааны бэрхшээлтэй иргэд /ХБИ/-д зориулсан DAISY төв

Нийт 27 ном МХҮХ-ноос хүлээж авсан бөгөөд бичлэг болон мэдээллийг (DAISY) стандартын дагуу бүтээгдсэн эсэхийг шалгаж тайлант хугацаанд 15 ном уншлаганд гаргасан байна.

Тайлант хугацаанд 60 орчим ХБИ-д дараах сэдвээр зөвлөмж өгсөн. Үүнд а/ Цахим ном уншигч төхөөрөмжийн хэрэглээ; б/ монгол хэлний ярьдаг програм болон компьютерийн хэрэглээ; в/ Facebook болон Gmail хэрэглэх; г/цахим брайлийг компьютерт хэрхэн суулгаж ашиглах тухай зөвлөмжүүд өгсөн байна.

ХБИ-д нийт 4 удаагийн технологийн сургалт зохион байгууллаа. Үүнд: ХБИ-ийн 116-р сургуулийн 4-р ангийн 8 сурагчдыг компьютерийн 10 хуруугаар бичиж сурах сургалт, МХҮХ-ний МСҮТ-ийн компьютерийн ангийн 4 суралцагчдыг хамруулсан “DAISY” технологийн 5-хоногийн сургалт, уншигчдын хүсэлтээр “DAISY” цахим ном тоглуулагч төхөөрөмжийн сургалт зохион байгуулж 10 ХБИ-ийг хамруулж тус тус зохион байгуулсан байна. Сүхбаатар аймгийн Хараагүйчүүдийн салбар зөвлөлийн урилгаар томилолтоор очиж 5 хоногийн сургалтыг 8 хүнд тус тус зохион байгуулсан байна.


Уншлага үйлчилгээнд ашиглагдаж байгаа компьютер, DAISY ном тоглуулагч брайль принтер болон бусад техник хэрэгсэлүүдийн нийт 8 компьютерт гарсан 20 орчим саатал доголдлыг засварлаж шинээр тохируулах дахин програмыг суулгах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд хийгдэх албан ёсны 4 удаагийн шинэчлэлт болон хуваарьт засвар үйлчилгээг нийт 14 компьютерт хийсэн. “Windows” 10 үйлдлийн системийн шинэчлэгдсэн хувилбар болон хараагүй хүний дэлгэц уншигч “NVDA” програм, Монгол хэлний ярьдаг програмууд бүрэн ажиллагаатай байна.



Тайлант хугацааны байдлаар тус төвийн YOUTUBE суваг, Facebook групп дээр дүрс бичлэг, зурагтай 50 орчим мэдээлэл, 70 гаруй нийтлэл оруулсан байна. YouTube: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний мэдээллийн суваг;

<https://www.youtube.com/watch?v=syUksUaXi8w>; Facebook групп: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн бүлэг

Тайлант хугацаанд уншлага үйлчилгээнд цахим брайлын эхний хувилбарыг бүрэн нэвтрүүлж дуусгалаа. Хараагүй хүний компьютерийн дэлгэц уншигч програм суулгасан бүх үйлчилгээний компьютерт цахим брайлийг ашиглах боломжтой болж, зуны хуваарьт програмын шинэчлэлт хийгдсэн.



ХБИ-д зориулсан технологийн шийдлүүдийг хөгжүүлэх ажлын хүрээнд дэлхий даяар хараагүй хүмүүсийн өргөн ашигладаг “NVDA” дэлгэц уншигч програмыг Монгол хэлнээ орчуулж хэрэглээнд оруулах ажлыг гүйцэтгэж хагас жилийн байдлаар орчуулгын ажлыг дуусгаж Монгол дэлгэц уншигч програмын эхний хувилбар гарахад бэлэн болсон байна.



“UBPL Braille and Digital Access Library Service of the Blind” хуудсыг хөтөлж, 35 удаагийн мэдээ мэдээлэл оруулсан.

DAISY студид E-PUB 3.0 цахим номны стандарт шинээр нэвтрүүлэх боломж бүрдсэнтэй холбоотойгоор компьютерийн бичвэрийг яриа болгох судалгааны ажлыг эхлүүлж 3 сайн дурийн хүмүүсийг хамруулсан боловч 2 сайн дурын ажилтантайгаар ажиллаж байна. Судалгааны хүрээнд 6000 орчим Монгол хэлний сонгомол өгүүлбэрүүдийг бичлэг болгосон.

ХБИ-ийн брайль болон цахим номын сангийн уншлага үйлчилгээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн чанар, хүртээмж, багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагааны болоод дэвшилтэд цахим техник технологийн ажлуудыг санаачлан хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд: Олон улсын номын “ABC GLOBAL BOOK SERVICE” үйлчилгээнд нэгдэн орлоо.





“DAISY E-PUB” цахим хэвлэлийн 3.0 стандартыг “DAISY студиэд нэвтрүүлэхээр програм хангамжийн шийдлийн судалгааг эхлүүлэн ажиллаж байна.

“DAISY E-PUB” цахим хэвлэлийн 3.0 Стандартыг судалж “DAISY” студиэд цахим номны хүртээмжтэй форматуудыг нэвтрүүлэх зорилгоор 20 хэвлэмэл номыг сонгож аваад сканнердаж цахим файл болгоод байна.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагын дэмжлэгтэйгээр хараагүй хүмүүсийн инноваци хөгжлийн төвөөс хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хүртээмжтэй форматаар цахим ном бүтээх чадавхийг нэмэгдүүлэх олон улсын сургалтыг Энэтхэг улсаас мэргэжилтэн урьж, 2018 оны 12 сарын 17-20-ны хооронд зохион байгуулах гэж байна.

Дэлхийн олон оронд хараагүй хүмүүсийн өргөн хэрэглэдэг “NVDA” компьютерийн дэлгэц уншигч програм хангамжийн монгол хувилбарын нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 12 сарын 20 өдөр зохион байгуулна.



3.1.8. Мэргэжил аргазүйн үйлчилгээ

Номын сангийн Мэргэжил аргазүйн зөвлөл, Олон нийтэд үйлчлэх тасаг, Маркетинг, инновацийн тасаг, Монголын номын сангуудын консорциум, БСШУСЯ, АНУ-ын ЭСЯам, Ерөнхий боловсролын болон их дээд сургуультай хамтран нийт 41 удаагийн сургалт, семинар, уулзалт, ярилцлага зохион байгуулан ажилласан. Эдгээр сургалтуудаас товч дурдвал:

Монголын номын сангуудын консорциум, БСШУСЯ, АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Номын санчдын цуврал сургалт”-ыг зохион явуулахаар болсон бөгөөд нэгдүгээр сард “Номын сангуудын хамтын ажиллагаа”, “Номын сангийн бүтээлч орон зай”, “Номын сангийн менежмент, маркетинг”, “Номын сангийн лавлагааны ажил” сэдвийн дор АНУ-ын төрийн департаментийн Бээжин дэх бүс нутаг хариуцсан төлөөлөгч, Америкийн соёл мэдээлийн төвүүдийг хариуцсан мэргэжилтэн Жон Даминикантониогоос сургалт авлаа. Сургалтанд бүх шатны номын сангуудын төлөөлөл 50 гаруй номын санчид хамрагдсан юм.



Цуврал сургалтын удаах сургалт нь Каталогч, номзүйчдийн хэлэлцүүлэгээр үргэлжилсэн юм. Хэлэлцүүлгийн үеэр каталогийн галиглал, MARC пормат, мэргэжлийн гарын авлага, Z39.50 протокол, мэдээллийг нэгнээсээ татаж авах боломжуудыг нээх талаар ярилцлаа. Хэлэлцүүлэгт 10 гаруй байгууллагын 33 хүн хамрагдлаа.

Хотын нийтийн төв номын сан, алслагдсан дүүргүүдийн буюу Багануур, Багахангай, Жаргалтын соёлын ордны номын санчдад каталогжуулалт болон ном сэлбэн засахын сургалтыг каталогч Н.Одхүү, сэлбэн засагч Ц.Одсүрэн нар зохион байгуулж, каталогжуулалтын сургалтад 20 хүн, сэлбэн засахын сургалтанд 6 хүн тус тус хамрагдав.



Mongolian Libraries Consortium – Монголын Номын Сангуудын Консорциум-аас Хэнтий аймгийн сумдын номын санчдад зориулсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд оролцсон номын санчид Улаанбаатар Хотын Төв номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.



123 орны 20000 орчим номын санг нэгтгэсэн “OCLC буюу Online Computer Library Center-ээс Ази ном далайн орнуудад зориулсан үйлчилгээ” сэдэвт сургалтыг 2018 оны 5-р сарын 17-ны өдөр Хотын нийтийн төв номын санд зохион байгууллаа. Илтгэгчээр OCLC-ийн Ази номхон далай хариуцсан дэд ерөнхийлөгч ноён Andrew Wang, гүйцэтгэх захирал хатагтай Shu En Tsai нар оролцож, OCLC байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэж, Ази номхон далайн орнуудын номын сангуудад зориулсан номын сан, номзүй, каталогийн үйлчилгээний танилцуулга зэрэг 11 бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ талаар танилцуулга хийж, ярилцлага өрнүүлж сонирхсон асуултанд хариулав. Уулзалт лекцийг БСШУСЯ, Монголын номын сангуудын консорциумын санаачлагаар Улаанбаатар хотын төв номын санд зохион байгууллаа.



ОХУ-ын Буриад хотын И.К.Калашниковийн нэрэмжит Улан-Үдэ хотын төв номын сангийн 50 жилийн ойн арга хэмжээнд ном зүйч О.Долгорсүрэн, ахлах номын санч Г.Баяржаргал, номын санч Д.Дэлгэрсайхан нар оролцож туршлага судлах 5 өдрийн сургалтад хамрагдаад ирлээ.

IVLP буюу Олон улсын манлайлагчдын зочин хөтөлбөрийн хүрээнд АНУ-д "Library resource management" сэдвээр туршлага судлах, мэдээлэл солилцох 10 өдрийн сургалтад Захиргаа, удирдлагын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Отгонбаяр, ОНУТ-ийн эрхлэгч В.Түвшинтогтох, хөтөлбөрийн номын санч Б.Шүрэнбагана нар хамрагдлаа. Уг сургалтын хүрээнд АНУ-ын Петтсбург хотын А.Карнегийн нэрэмжит харааны бэрхшээлтэй иргэдийн номын сантай хамтран ажиллахаар боллоо. Сургалтад хамрагдаж ирсэн ажилтнууд 06 дугаар сарын 27, 28-ны өдрүүд, мөн 07 дугаар сарын сүүлч, 08 дугаар сарын эхээр орон нутгын номын санч нарт зориулсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.



“Мөнх тэнгэр” Монгол туургатны соёл, урлагийн их наадмыг энэ сарын 6-наас 8-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд болж өнгөрлөө. Наадамд Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шиньжян Уйгарын Өөртөө засах орон, Хөх нуур муж, ОХУ-ын Буриад, Тува, Халимаг, Алтай, Сахагийн Бүгд найрамдах улсын нийт 200 гаруй төлөөлөгчид, Монгол Улсын мэргэжлийн урлагийн уран бүтээлчид болон соёлын биет бус өвийн өвлөн тээгчид, соёлын үйлдвэрлэл эрхлэгчид оролцлоо. Наадмын үеэр Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн тасаг салбарын ажилтнууд, Нийслэлийн Соёл Урлагийн Газартай хамтран явуулдаг “Номоо солилцъё” өдөрлөгийг зохион байгуулж, “Монгол туургатны өв соёл” сэдвийн дор номын үзэсгэлэн, ЕБС төгсөгчдөд мэргэжлээ хэрхэн сонгох зөвлөгөө өгч ажиллалаа.



Дэлхийн хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Global Youth Entrepreneurship 2018” уралдаанд монголоос оролцох багийг бэлтгэх зорилготой “Залуу Энтрепренерүүдийн ур чавдарын сургалт”-ыг “Save the Children”, “Хөгжлийн Шийдэл” ТББ-тай хамтран ЕБ-ын 5, 23, 72, 57, 117, 121, “New Era”, “Орчлон” зэрэг сургуулийн 12-р ангийн сурагчдыг хамруулж 6 удаагийн сургалт зохион байгуулсан. Тэмцээний сүүлийн шатанд үндэсний хэмжээний ялагчаа тодруулахад “New Era” сургуулийн “Эрчим, Хүч” баг нарны зайн энергиэр ажилладаг усалгааны роботоороо тэргүүн байрыг эзлэн 8 сард Малайзын Куала Лампурт болох тэмцээний эрхийг гардан авсан.



Кино үдэш хөтөлбөрөөр “She started it” буюу “Гарааны бизнес эрхлэгч эмэгтэйчүүд” (Thuy, Stacey, Sheena, Brienne, Agathe) нарын амьдралыг харуулсан баримтат кино, “Makers: Women who Make America” буюу “Бүтээгчид: Америкийг бүтээдэг эмэгтэйчүүд” зэрэг киног уншигчдад үзүүллээ.



3.2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар

Номын сангийн Мэргэжил аргагүйн зөвлөл, Олон нийтэд үйлчлэх тасаг, Маркетинг, инновацийн тасаг, Монголын номын сангуудын консорциум, БСШУСЯ, АНУ-ын ЭСЯам, Ерөнхий боловсролын болон их дээд сургуультай хамтран нийт 41 удаагийн сургалт, семинар, уулзалт, ярилцлага зохион байгуулан ажилласан. Нийт ажиллагсдын 85-93 хувийн ирцтэй хамрагдсан байна. Үүнээс АНУ руу 4 ажилтан, БНХАУ руу 1 ажилтан, ОХУ руу 3 ажилтан мэргэжлийн дагуу сургалтад тус тус хамрагдсан.

Тус номын санд 3-аас дээш жил ажилласан, мэргэжил шаардсан 37 албан тушаалд одоо ажиллаж байгаа ажиллагсдын 36 нь буюу 97,3% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Нийт 39 ажилтнуудыг дээд шатны байгууллагын шагнал, НСУГ-ын шагнал, дотоод болон бусад шагналаар шагнуулахаар тодорхойлсон. Үүнээс 28 ажилтан шагнагдаж зохих журмын дагуу урамшуулал олгосон.

Одоо ажиллаж байгаа ажиллагсдын 50% буюу 33 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож, 15 ажилтны цалингийн шатлалыг ахиулж, 1 ажилтанд зэрэг дэвийн нэмэгдэл олгосон.

Ажилтан бүрт сар бүр хоол унааны мөнгө 60.000 төгрөг олгодог.

3.3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Тайлант хугацаанд ирсэн 23 өргөдөл ирснээс 22 нь байгууллагад бичгээр, 1 өргөдөл нь Засгийн газрын 11-11 төвөөр тус тус ирснийг бүртгэлийн дэвтрээр болон www.1200.mn цахим системд бүртгэн 100 хувь барагдуулж ажилласан.

Байгууллагын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 3 цаг 39 минут, өргөдөл гомдлын индекс 0,87 “А” үнэлгээтэй. Шийдвэрлэлтийн дундаж хугацааг 2017 оныхтой харьцуулахад /2017 оны 11 хоног 19 цаг 50 минут/ 5 хоног 16 цаг 11 минутаар буурсан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам буюу 4 удаа гаргаж НЗДТГазар руу хүргүүлж ажилласан.

Дөрөв. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Үйл ажиллагааны ил тод байдал:

Тус номын сангаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, уншигчаар бүртгүүлэх, гэрээр ном авахад шаардлагатай баримт бичиг, ажлын цагийн хуваарь, үйлчилгээний журам, дотоод журам, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, арга хэмжээний зар мэдээ зэрэг иргэдэд зайлшгүй шаардлагатай **77** холбогдох мэдээ, мэдээллийг www.pl.ub.gov.mn цахим хуудсаараа мэдээлсэн.

Номын сангийн захирлын 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/03 дугаар “Төлбөрт үйлчилгээний үнийг шинэчлэх батлах” тушаалыг, үйлчилгээ авахад шаардах баримт бичгийн жагсаалт болон холбогдох мэдээллийг хамт ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан байгаа. Номын сангийн тухай хууль, Номын сангийн үйлчилгээний журмыг уншигчдад ойлгомжтой байдлаар зурган болон видео бичлэгээр хийж вэб сайт, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээ, номын сангийн үүдэнд байрлах дэлгэцээр тус тус сурталчиллаа.

Номын сангийн эрхлэгч нарын овог нэр, албан тушаал, харилцах утас, ажиллах цагийн хуваарийн хамт цахим хуудсанд болон мэдээллийн самбартаа байршуулсан.

4.2. Хүний нөөцийн ил тод байдал:

Номын сангийн цахим хуудасны нээлттэй ажлын байр цэсэнд сул орон тооны зарыг 6 удаа байршуулан тухай бүр шинэчилж байгаа. Үүнд: номын санч 3, хуулийн зөвлөх, хүний нөөцийн мэргэжилтэн 1, сүлжээний инженер 1, үйлчлэгч 1.

Номын сангийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг номын сангийн захирлын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталж, цахим хуудсандаа болон мэдээллийн самбартаа байршуулсан.

Тайлант хугацаанд мэргэжил шаардсан 47 албан тушаалд ажиллаж байгаа ажиллагсдын 45 нь буюу 95,7% мэргэжлийн дагуу ажиллаж байгаа.

Тав. БУСАД МЭДЭЭЛЭЛ

Соёл, олон нийтийн ажлын талаар


Төв болон салбар номын сангуудын хэмжээнд соёл, танин мэдэхүйн ажлуудаа Нийслэлийн Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн зорилтын дагуу төлөвлөн явуулахын зэрэгцээ өсвөр үе, залуучуудыг соён гэгээрүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хэрэгцээтэй мэдлэг мэдээллээр хангахад чиглүүлэн дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

д/д	Үйл ажиллагааны ерөнхий нэр	Давтамж	Хамрагдсан хүний тоо
1	Уулзалт лекц	69	3247
2	Уралдаан, тэмцээн	42	988
3	Сургалт	58	2249
4	Тойм яриа	10	217
5	Зөвлөмж яриа	29	758
6	Чанга уншлага	67	1247
7	Кино үдэш	26	378
8	Номын нээлт	11	394
9	Бусад	8	203
	Нийт	320	9681

	Номын үзэсгэлэн	Давтамж	Номын тоо
1	Шинэ номын үзэсгэлэн	48	754
2	Сэдэвчилсэн номын үзэсгэлэн	169	1897 ном, 32 судар, 214 хэвлэмэл материал
3	Байнгын үзэсгэлэн	27	287
	Нийт	244	

Эдгээрээс томоохон соёл олон нийтийн ажлаас дурдвал:

СУИС-тай хамтран РТМУС-ийн авьяаслаг оюутан залуусын шинэ, шилдэг уран бүтээлүүдээс бүрдсэн “CREATIVITY” гэрэл зургийн үзэсгэлэнг 2018 оны 03 сарын 07-ны өдрөөс 03 сарын 10-ыг дуустал Улаанбаатар хотын төв номын санд гаргалаа.



Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, хүүхдүүдийн гэр бүлийн уур амьсгалыг дэмжих зорилгоор “Миний ээж” сэдэвт шүлгийн уралдааныг уншлагын

“Б” танхимаас зохион байгуулсан бөгөөд уралдаанд нийт 13 бүтээл ирснээс 1-р байранд Д. Энхжаргал, 2-р байранд Б.Мөнгөнчимэг, 3-р байранд Д.Оюундарь тус тус шалгарлаа. Уралдаанд ирсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж олон нийтэд үзүүлээ.



Сурагчдын Англи хэлний боловсролд зориулан 2018 оны 2 сарын 12-нд “Үг үсэглэлийн тэмцээн”-ийг уншигчдын дунд зохион явуулж уншигч н.Дөлгөөн, н.Тэмүүлэн, Хулан нар амжилттай оролцож эхний гурван байрыг эзэллээ.



Мөн Англи хэлээр Чанга уншлагын хичээл зохион байгууллаа. Чанга уншлагад "Онол" дунд сургууль болон Аксэс хөтөлбөрийн нийт 21 сурагчид оролцож "Өглөгийн мод" номыг Англи хэлний багш н.Тансагтай хамт хичээнгүйлэн уншиж дараа нь тус номын тухай хэлэцүүлэг хийв.



Продюсер, яруу найрагч, сэтгүүлч Б.Шүүдэрцэцэгийг урин 52,75,15-р сургуулийн 6-9 – р ангийн нийт 81-н сурагчидад уулзалт зохиов уулзалтанд оролцсон сурагчид 23 асуулт асууж амжилттай сайн оролцлоо.11ш номоор үзэсгэлэн гаргав.



Д.Нацагдоржоор овоглосон Улаанбаатар хотын нийтийн төв номын сангаас 2018 оны 03 дугаар сараас эхлэн сар бүр Д.Нацагдоржийн шагналт зохиолчидтой “Уулзалт, өдөрлөг” зохион байгуулахаар болсон. Үүнд: Д.Нацагдоржийн шагналт зохиолч Ц.Буянзаяа, Б.Баярсайхан, Ш.Бадарч, Ц.Доржготов, Б.Хүрэлбаатар, Ц.Түмэнбаяр, Г.Жигжидсүрэн нартай уулзалт ярилцлага хийсэн. Уулзалтад нийт 360 гаруй уншигч, иргэд хамрагдлаа.



Д.НАЦАГДОРЖИЙН ШАГНАЛТ
ЗОХИОЛЧИДТОЙ ХИЙХ
“УУЛЗАЛТ-ӨДӨРЛӨГ”
АНХНЫ ЗОЧИН ЗОХИОЛЧ Ц.БУЯНЗАЯА

- “Сэтгэлгээний чөлөөлт ба орчин үе” лекц
- “Хар үхэр, алаг сүүдэр” романы нээлт
- Гарын үсэгтэй, хямдралтай номын худалдаа


Хэзээ: 2018.03.15-ны өдөр 11:00 цагт
Хаана: Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын санд



Д.НАЦАГДОРЖИЙН ШАГНАЛТ
ЗОХИОЛЧИДТОЙ ХИЙХ
“УУЛЗАЛТ-ӨДӨРЛӨГ”
МУСГЗ яруу найрагч, сэтгүүлч
Бямбажавын Хүрэлбаатар

1992 онд “Хүлгийн зоонд олод гялалзана” номоор МЗЭ-ийн шагнал
2000 онд “Хадагтай морьд” номоор Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал
2009 онд МУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн цолоор тус тус шагнагдсан.
“Цэцэг нуурын хөвөөнд”, “Миний Улаанбаатар”, “Сутай хайрхан уу!”
зэрэг шүлэг нь дуу болон ард олонд түгжээ.

Хэзээ: 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 15.00 цагт
Хаана: Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын санд



ХЭЗЭЭ: 2018 оны 05 сарын 31-ны өдрийн 12:00 цагт
ХААНА: Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын санд





Америкийн боловсролын зөвлөгөөний төв нь 2018 оны 02 дугаар сараас эхлэн Увс, Ховд болон Дорноговь аймгийн номын сантай хамтран онлайн уулзалтыг явуулж эхэлсэн бөгөөд нийт 5 удаагийн онлайн зөвлөгөөг 38 оюутан сурагчдад хүргэсэн.



Сурагчдын амралт эхэлсэн байгаатай холбогдуулан 03 сарын 27-ноос 04 сарын 01-ны өдрийг хүртэл ЕБС-ийн 1, 2, 3-р ангийн сурагчдад зориулан “Хурдан уншлага” унших чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлээ. Уг хөтөлбөрийн хүрээнд



Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын төв номын сангийн төлөөлөл Их Засаг Их Сургуулийн Хууль Зүйн Сургуульд болж буй Оюутныг угтан авах өдөрлөгт оролцож байна. Өдөрлөгийн хүрээнд тус сургуулийн нэгдүгээр курсийн 500 оюутанд Д.Нацагдоржийн номын сангийн төв болон салбар номын сангийн хаяг байршил, номын сангийн үйлчилгээний танилцуулгыг хийж, 30 гаруй оюутанд уншигчийн карт нээлээ.Цаашид номын солилцоо хийх,

зөөврийн номын сан ажиллуулах, номын санчдыг туршлага судлуулах, хуулийн болон бусад мэргэжлийн сургалтад хамруулах чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.



"Номоо солилцъё" өдөрлөгийн хүрээнд ах дүүгийн найрамдалт харилцаат БНСУ-ын Намянжү хотын иргэд манай номын санд 500 гаруй хүүхдийн номоор "Намянжү хотын номын булан"-г байгууллаа. Хүрэлцэн ирсэн иргэд манай номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, номын санч, номын сангийн удирдагууд, НСУГ-ын төлөөлөлд Намянжү хотын номын сангийн тухай танилцууллаа. Үүний дараагаар хоёр хотын номын сангийн хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцлоо. Өдөрлөгийн хүрээнд Солонгос хувцас өмсөж үзэх, Солонгос бичгээр бичих, 3D зураг зурах, номоо солилцох хөтөлбөрүүд зохион байгуулагдсан.



Номын санд зочлон ирсэн хэрэглэгч, байгууллага хамт олонд номын сангаа танилцуулж, богино хэмжээний мэдээлэл 2 удаа хийсэн. Үүнд: Ховд аймгийн Нийтийн номын сангийн 12 ажилтан, Булган аймгийн Сумын соёлын төвийн эрхлэгч 13 хүн тус хамрагдсан.




Номын нээлт:

1. Ерөнхийлөгч асан П.Очирбат “Тэнгэрийн цаг”
2. Зохиолч Л.Сарантуяагийн “Гурван цагийн аяс”,
3. Зохиолч Ц.Ариунтуяа “Тэнгэрийн охины зүүд”
4. Зохиолч Ц.Буянзаяа “Хар үхэр, алаг сүүдэр”
5. Зохиолч, утга зохиолын шүүмжлэгч Д.Батхуягийн “О.Дашбалбар”,
6. Сэтгүүлч Н.Золзаяа “Австралид 820 хоног”
7. Түүхч Ч.Жазаг “Гэгээн судар”
8. Яруу найрагч Б.Сундуй “Бичигдээгүй шүлэг”
9. Яруу найрагч Г.Баяр “Бугын толгойтын гарам”
10. Яруу найрагч Д.Нямдорж “Тэнгэрийн дусал шиг цэнхэр тагтаа”
11. Яруу найрагч Т.Нарангэрэлийн “Даашинзны хээтэй шүлгүүд”


5.2. Байгууллагынхаа үйл ажиллагааны үр дүнгийн талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн байдал:

Номын сангийн соёл олон нийтийн ажлын үр дүнг судлах, цаашид хийх ажлын санал хүсэлтийг дараа дараачийн ажлууддаа тусгаж хэрэгжүүлэх үүднээс “СОНА-ын судалгаа”-г 100 уншигчаас авсан.


Үйлчлүүлэгчийн хүйсийн байдлаар харуулбал: /тайлбар: бусад гэдэг нь хүйсээ бичээгүй болон саармаг хүйстэн/




Үйлчлүүлэгчийн насны байдлаар харуулбал:



Та номын санд ямар үйлчилгээ авахаар ирдэг вэ? асуултад хариулсан байдлаар харуулбал:



Та тус номын сангийн талаарх мэдээ мэдээллийг хаанаас олж авдаг вэ? асуултад хариулсан байдлаар харуулбал:



Таны үйлчилгээ авч байгаа эдгээр үйл ажиллагаанууд таны хэрэгцээ, шаардлагыг хангадаг уу? асуултад хариулсан байдлаар харуулбал:



Цаашид номын сангаас ямар үйл ажиллагаа, хөтөлбөр явуулаасай гэж хүсдэг вэ? (Өөрийн бодож, хүсдэг зүйлээ тодорхой бичихийг хүсэж байна.)

1. Миний хайж буй сурах бичиг, мөн ном сурах бичиг оюутны болзлыг хангахуйц байвал тэдгээрийн сурах их үйлсэд ихээр нөлөөлнө.
2. Оюутан залуусыг хамарсан хөгжөөнт тэмцээн байгуулах
3. Халаалт сайжруулах, аха, оюутан залуус, ЕБС сурагчдын дунд хөгжөөнт уралдаан тэмцээн зохион байгуулах,
4. Компьютер цэнэглэх залгуурыг засах, нэмэх
5. Шинээр хэвлэгдсэн шинэ хууль, сурах бичиг, сонин сэтгүүлийг тэр даруйд нь танхимд тавих нь зүйтэй.
6. Интернет бас номоо хүссэнээрээ авч уншаад буцаагаад тавих ч юмуу гэхдээ ихэнх хүмүүс номын сангийн зүйлтэй замбараагүй харьцдаг болохоор бас тэр тал дээр хэцүүл байх. Бас би энэ номын санд орох дуртай ч интернет эсвэл facebook хаягаар мэдээлэл авья гэхээр болдоггүй. Заримдаа гэнэт ажилладаггүй, розетканууд нь ажилладаггүй.
7. Номынхоо хүрээг тэлэх, шинээр гарсан болон ангаагахын чиглэлийн ном олон болоосой гэж хүсэж байна.
8. Номын сангийн үйлчилгээний ажилтнуудын соёлыг улам сайжруулаасай, Залуучуудад чиглэсэн номын сонголт зөв уншлагын сургалт хөтөлбөр зохион байгуулвал маш хэрэгтэй байна.
9. Нийт уншигчдыг хамарсан ном унших, хөтлөх тэмцээн, номын солилцоо,
10. Номын фонд нэмэх, уншлагын танхимын ширээ сандлыг нэмэх.
11. Номоо хайж олоход бэрхшээлтэй байна.
12. Тэтгэлэг болон гадаадад сурахтай холбоотой уулзалт, лекцийг олон зохион байгуулах, үйлчлүүлэгчдийн цай хоол иддэг булантай болох, Оюутнууд амрах жижиг хэсэгтэй тэндээ хоолоо халаадаг богино долгионы зуух байрлуулах
13. Тэргүүний уншигч шалгаруулах, Танин мэдэхүйн АХА тэмцээн
14. Е-номын сан ингэснээр гэрээсээ ч номын санд сууж болно
15. Уншигчдын дунд тодорхой сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж болно. Хэлэлцүүлэг ашиглаж болох номын жагсаалтыг гаргаж чиглэл өгч болох юм. Мөн сонгодог жүжгийн зохиолуудаар жүжигчилсэн тоглолт хийвэл сонирхолтой байх болно.
16. Номын сандаа эрдэмтэн профессор алдартай хүмүүсийг урьж лекц сардаа 1, 2 зохион байгуулдаг байгаасай гэж хүсэж байна.
17. Хувцас өлгүүрийн үйлчилгээг сайжруулах

18. Номын сан хүйтэн байна, Илүү халаалтын тал дээр анхаарч өгнө үү. Хувийн номтой ордог танхимийн том зааланд оруулж өгнө үү. Номын санд жижиг буфет ажиллуулах боломжтой юу,
19. Гэрээр гардаггүй номнуудыг гаргах, гэрээр олгож байгаа номнуудын үнийг багасгах,
20. 00-оо сайн цэвэрлэж бас халаалтын асуудлыг шийдэж өгөөчээ,
21. Ус буцалгагчаа нэмэгдүүлэх, 00 цэвэрхэн байлгах, ном хандивлах аян байгуулвал ном өгнө.
22. номын нээлттэй өдөрлөг, Баяртай холбоотой номыг чөлөөтэй уншуулах
23. номын сангийн үнэмлэхэд хавтас байвал зүгээр, дэлгүүр бичиг хэрэг
24. Номын солилцоо, хандивын аргаар номын тоогоо нэмэгдүүлж номын чанараа сайжруулах, ус буцалгагчын тоогоо нэмэх, ном хандивлах аян зохион байгуулвал ном өгнө
25. Шинэ гарсан зохиол, номнуудаар номын сангаа илүү баяжуулах, оюутан сурагч нарт зориулсан арга хэмжээ зохион байгуулах
26. номын цагийн ажиллах цагийг уртасгах, хоол унд идэх газартай болох дулаан байлгах
27. 7 хоногт 1 удаа номын хэлэлцүүлэг болох
28. 24 цагийн танхимтай болвол оюутан сурагчидад маш их үр өгөөжтэй. Хэрэв нээвэл төлбөртэй байж болно шүү дээ. Мөн ажилчдынхаа харилцаа хандлага ёс зүйн тал дээр улам их хичээж ажиллаарай. Цэвэрхэн тохилог бас харилцаа хандлага бусдыгаа бодвол дээр учраас би хичээлээ хийж суух дуртай,
29. Зарим номын хэрэгцээ тоогоо ихэсгэх, гэрээр олгодог байгаасай, цөөхөн номоо нэг хоногоор ч болов олгодог бол
30. интернет орчин сайтай олон номтой болмоор байна. Өлгүүрийн эгч нарын харилцааны соёл муу.
31. Илтгэл, сургамжтай хүмүүсийн яриа
32. Уншлагын танхимд халаалт хэрэгтэй байна.
33. Тэргүүний уншигч шалгаруулах, уран унших тэмцээн явуулах
34. Сургалт сайн явуулах хэрэгцээт мэдээллээр хангах
35. Номын өдөрлөг зохиож шинэ сүүлийн үеийн номуудыг оюутан залууст хүртээж байх
36. Лектор хүмүүстэй уулзах хэрэгтэй лекц сонсгох
37. Хэрэглэгч бүрт хүрч үйлчилдэг байгаасай.
38. Япон хэлний номнууд авах
39. Уншлагын танхимын халаалтыг нэмж өгөхийг хүсэж байна

Судалгаанд хийсэн дүгнэлт:

Номын сангаар үйлчлүүлэгсдийн дийлэнх хувийг охид, эмэгтэйчүүд эзэлдэг, үйлчлүүлэгчдийн насыг авч үзвэл ахлах ангийн сурагчид мөн оюутан залуус буюу 17-21 насныхан байна. Энэ хүмүүс номын санд хичээлээ хийх дулаан, чимээгүй орчинг хүсэж ирдэг төдийгүй тодорхой хувь нь ном гэрээр авах, мөн хувийн номтойгоо /ЭЕ шалгалт, гадаа хэлний шалгалт, сургуулийн сурах бичиг, гарын авлага/ ирж хичээлээ хийх сонирхолтой байдаг байна.

Санал:

1. Төв номын сангийн харьяа салбар номын сангуудын байрыг стандарт шаардлагад нийцсэн байртай болгох. /Тухайлбал Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан орон сууцны 1 давхарт, Чингэлтэй, Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан үйлчилгээний төвийн байранд байрлаж байгаа/



Чингэлтэй дүүрэг дэх салбар номын сан нь Чингэлтэй дүүргийн 4-р хорооны 6-р байрны 1-р давхарт байрладаг.



Хан-Уул дүүрэг дэх салбар номын сан нь Хан-Уул дүүргийн 2-р хороо, Жаргалант үйлчилгээний төвийн 2-р давхарт байрладаг.



Баянзүрх дүүрэг дэх салбар номын сан нь Баянзүрх дүүргийн 1-р хороо, 12-р хороолол, 58 дугаар байрны 1-р давхарт байрладаг.

2. Номын санд жилдээ ном бүрдүүлэлтэд 21 сая төгрөг төсөвлөгддөг. Үүнээс 4,5 сая нь хэвлэл захиалгад, үлдсэн нь ном бүрдүүлэлт. Уншигч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээтэй номуудыг худалдан авахад 35%-ийг л хангаж байна. Энэ нь номын сангийн нийт зардлын 3 хүрэхгүй хувийн эзэлдэг. Иймд уншигчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн номуудаар номын бүрдүүлэлт хийхэд төсөв мөнгөний хувьд хангалтгүй, хүрэлцээ муутай байна.
3. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” А/920 дугаар захирамжаар 80 хүний орон тоотой баталсан. Гэтэл 80 хүний орон тооны батлагдсан цалингийн зардал одоо 68 хүний цалингийн төсөвт багтаан ажиллахаар байна.
Ийнхүү төсвийн хүндрэлтэй байдлаас болж номын сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй болоод байна. Тухайлбал 6 номын сангийн ажиллах орон тоонд 4 номын санч ажиллаж байгаа.
4. 2018 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтын 50 сая төгрөгөөр RFID системийг нэвтрүүлэхэд шаардлагатай нэмэлтээр ирсэн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авснаар Төв номын сангийн зөвхөн “А” танхимд бүрэн нэвтрүүлэх боломжтой болсон. Цаашид номын сангийн төв болон салбар номын сангийн хэмжээнд RFID системийг бүрэн нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
ЗАХИРАЛ

Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
АРХИВ, БИЧИГ
ХЭРГИЙН АЖИЛТАН

М.ЭНХ-УЯНГА